

**ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ,
ШААРДЛАГЫН
УРЬДЧИЛСАН ТАНДАН СУДАЛГАА**

УДИРТГАЛ

АГУУЛГА

УДИРТГАЛ	1
НЭГ. АСУУДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ	2
ХОЁР.АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ	2
ГУРАВ.АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫН ХАРЬЦУУЛАЛТ	
ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ.....	5
4.1. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	6
4.2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх	6

НЭГ. АСУУДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын Үндсэн хуулийн¹ нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах улс мөн.” гэж заасан бөгөөд Үндэсний их баяр наадам нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэдэл төдийгүй уламжлалт урлаг, спорт, биет бус өв бөгөөд эх оронч үзэл санаа дэлгэрэн хөгжихөд ач холбогдолтой юм.

Үндэсний их баяр наадмын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг Улсын Их Хурал 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр баталсан бөгөөд энэ хуулийн 10 дугаар зүйлийн 10.19-т “Үндэсний их баяр наадмаар жороо морины уралдааныг зохион байгуулж болно.” гэж заасан.

Монголчуудын эртний уламжлалт тэмцээний нэг нь жороо морин уралдаан юм. 1996 оноос эхлэн жил бүрийн баяр наадмын сүүлийн өдөр буюу 7 дугаар сарын 13-ны өдөр Уяачдын наадмаар жороо морины уралдааныг зохион байгуулсаар ирсэн.

Эрт үеэс Монголчуудын адуу болгонд байдаггүй жороолох энэ өвөрмөц явдлыг дээдлэн найр наадам, баяр ёслол, гоёлд унадаг унаа болгон уламжлагдаж ирсэн өнө эртний баялаг түүхтэй. Адууны сайварлах, жороолох явдлыг нүүдэлчин ахуй амьдралын ухаан туршлагаараа ялган ангилж, байгалийн үзэгдэл, амьтны хөдөлгөөнтэй зүйрлэн усан тэлмэн жороо, хонин жороо, тэмээн жороо зэргээр нэрлэж хэрэглэгдсээр ирсэн уламжлалтай.

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 10.19-т заасны дагуу зохион байгуулах жороо морины уралдаанд морь нь түрүүлсэн, айрагдсан уяачид улс, аймаг, сумын цол, чимгийг олгох нь эрт үеэс уламжлагдан ирсэн жороо морины уралдааныг дэлгэрүүлэн хөгжүүлэх, наадамчин олны жороо морио дээдлэн хүндлэх, хайрлах, хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэх, уяачдын хөдөлмөрийг үнэлэхэд чухал ач холбогдолтой гэж үзлээ.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалт нь өөр хоорондоо зөрчилдөхгүй бөгөөд жороо морины уралдаанд морь нь түрүүлсэн, айрагдсан уяачид улс, аймаг, сумын цол, чимэг олгох эрх зүйн зохицуулалтыг хуульд нэмж тусгасан болно.

Мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.9-д өөрчлөлт оруулж, жороо морины уралдааны уяачийн амжилтыг тооцож, цол олгохдоо тухайн уралдааныг зохион байгуулж байгаа үндэсний хурдан морины салбар хороонд уяачаар бүртгүүлсэн иргэний амжилтад тооцон уг цолыг олгох бөгөөд түрүүлсэн, айрагдсан нэг морины нэг удаагийн амжилт нь зөвхөн энэ зүйлд заасан нэг уяачид цол олгох үндэслэл болно.

ХОЁР.АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

1996 оноос эхлэн жил бүрийн баяр наадмын сүүлийн өдөр буюу 7 дугаар сарын 13-ны өдөр Уяачдын наадмаар жороо морины уралдааныг зохион байгуулдаг

¹ Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн,

хэдий ч уяачид цол, чимэг олгох асуудал орхигдсоор ирсэн. Энэ нь нэг талаас наадамчин олны хамгийн их үзэх сонирхолтой морины уралдаан болсон хэдий ч жороо морины уяачдын хөдөлмөрийг үнэлэх, жороо морины уралдааныг дэлгэрүүлэн хөгжүүлэхэд тодорхой ахиц дэвшил гарахгүй байна.

Түүнчлэн Үндэсний их баяр наадам нь Монголын соёлын өв болохын хувьд жороо морины уралдааныг уламжлалт байдлаар цаашид хадгалж үлдэх нь зүйтэй байна.

Наадамчин олны баяр бахдалыг төрүүлсэн жороо морины уралдаан нь өнөөг хүртэл уламжлагдан ирсэн үндэсний ухамсар, өв соёлын салшгүй нэг хэсэг болохын хувьд энэхүү түүхэн өв соёлыг хойч үедээ өвлүүлэн хадгалах, түгээн дэлгэрүүлэх шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Үндэсний их баяр наадмаар түрүүлсэн, айрагдсан хурдан морьдын уяачид цол, чимэг олгохоос гадна жороо морины уралдаанд түрүүлсэн, айрагдсан морьдын уяачид цол, чимэг олгох нь уяачдын цолны үнэлэмж, чанарыг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

Дээрх хууль зүйн болон практик үндэслэл, шаардлагад үндэслэн Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл нь 3 зүйлтэй бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт заасны дагуу хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсрууллаа.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь жороо морины уралдаанд морь нь түрүүлсэн, айрагдсан уяачид цол, чимэг олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ГУРАВ.АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫН ХАРЬЦУУЛАЛТ

3.1 Асуудлыг зохицуулах хувилбар

3.1.1."Тэг" хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах: Үндэсний баяр наадмын тухай хуульд жороо морины уралдааны талаарх зохицуулалтыг хийлгүй үлдээснээр 1996 оноос эхлэн жил бүрийн баяр наадмын сүүлийн өдөр буюу 7 дугаар сарын 13-ны өдөр Уяачдын наадмаар жороо морины уралдааныг зохион байгуулдаг хэдий ч уяачид цол, чимэг олгох асуудал орхигдсоор ирсэн. Энэ нь нэг талаас наадамчин олны хамгийн их үзэх сонирхолтой морины уралдаан болсон хэдий ч жороо морины уяачдын хөдөлмөрийг үнэлэх, жороо морины уралдааныг дэлгэрүүлэн хөгжүүлэхэд тодорхой ахиц дэвшил гарахгүй хэвээр үлдэнэ.

3.1.2.Хэвлэл мэдээлэл болон бусад хэрэгслийг ашиглан олон нийтэд хандсан ухуулга сурталчилгааны ажил өрнүүлэх: Үндэсний их баяр наадам нь Монголын соёлын өв болохын хувьд жороо морины уралдааныг уламжлалт байдлаар цаашид хадгалж үлдэх нь зүйтэй байна.

Наадамчин олны баяр бахдалыг төрүүлсэн жороо морины уралдаан нь өнөөг хүртэл уламжлагдан ирсэн үндэсний ухамсар, өв соёлын салшгүй нэг хэсэг болохын хувьд энэхүү түүхэн өв соёлыг хойч үедээ өвлүүлэн хадгалах, түгээн дэлгэрүүлэх шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Үндэсний их баяр наадмаар түрүүлсэн, айрагдсан хурдан морьдын уяачид цол, чимэг олгохоос гадна жороо морины уралдаанд түрүүлсэн, айрагдсан морьдын уяачид цол, чимэг олгох нь уяачдын цолны үнэлэмж, чанарыг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

3.1.3. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах: Асуудлыг шийдвэрлэх хувилбаруудыг харьцуулж тоймлон үзвэл:

Хүснэгт 1 Хувилбарын харьцуулалт.

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
Тэг хувилбар	Үндэсний баяр наадмын тухай хуульд жороо морины уралдааны талаарх зохицуулалтыг хийлгүй үлдээснээр 1996 оноос эхлэн жил бүрийн баяр наадмын сүүлийн өдөр буюу 7 дугаар сарын 13-ны өдөр Уяачдын наадмаар жороо морины уралдааныг зохион байгуулдаг хэдий ч уяачид цол, чимэг олгох асуудал орхигдсоор ирсэн. Энэ нь нэг талаас наадамчин олны хамгийн их үзэх сонирхолтой морины уралдаан болсон хэдий ч жороо морины уяачдын хөдөлмөрийг үнэлэх, жороо морины уралдааныг дэлгэрүүлэн хөгжүүлэхэд тодорхой ахиц дэвшил гарахгүй хэвээр үлдэнэ.	Зардал гарахгүй боловч наадамчин олны хүсэл сонирхолд нийцсэн шийдвэр гарахгүй байх.	Эерэг, сөрөг үр дагаваргүй
Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Үндэсний их баяр наадам нь Монголын соёлын өв болохын хувьд жороо морины уралдааныг уламжлалт байдлаар цаашид хадгалж үлдэх нь зүйтэй байна.	Хэвлэл мэдээлэл, олон нийтэд таниулах зорилготой холбоотой сургалт, нэвтрүүлэг, ухуулаг хийх нэмэлт зардал гарах гарах шаардлагагүй бөгөөд	Эерэг үр дүнтэй

	Наадамчин олны баяр бахдалыг төрүүлсэн жороо морины уралдаан нь өнөөг хүртэл уламжлагдан ирсэн үндэсний ухамсар, өв соёлын салшгүй нэг хэсэг болохын хувьд энэхүү түүхэн өв соёлыг хойч үедээ өвлүүлэн хадгалах, түгээн дэлгэрүүлэх шаардлага зүй ёсоор урган гарч байна.	Үндэсний их баяр наадмаар түрүүлсэн, айрагдсан хурдан морьдын уяачид цол, чимэг олгохоос гадна жороо морины уралдаанд түрүүлсэн, айрагдсан морьдын уяачид цол, чимэг олгох нь уяачдын цолны үнэлэмж, чанарыг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.	
Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь жороо морины уралдаанд морь нь түрүүлсэн, айрагдсан уяачид цол, чимэг олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	Улсын төсөвт нэмэлт зардал нэмэгдэхгүй. Асуудлыг шийдвэрлэснээр өв уламжлалаа хадгалах, хосгүй үнэт зүйлийн эрх зүйн байдал тодорхой болох	Эерэг үр дүнтэй.

Хувилбаруудын зорилгод хүрэх байдал болон эерэг ба сөрөг талыг зардал, үр өгөөжөөр харьцуулсны үр дүнд "хуулийн төсөл боловсруулах" нь асуудлыг шийдвэрлэх ганц хувилбар байгаа буюу хууль гаргах хэрэгцээ, шаардлагатай гэж үзсэн тул тандан судлах ажиллагааг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

ДӨРӨВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАНУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах улс мөн.” гэж заасан. Энэ утгаараа Үндэсний их баяр наадам нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэдэл төдийгүй уламжлалт урлаг, спорт, биет бус өв бөгөөд эх оронч үзэл санаа дэлгэрэн хөгжихөд чухал ач холбогдолтой юм.

Үндэсний их баяр наадмын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг Улсын Их Хурал 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр баталсан бөгөөд энэ хуулийн 10 дугаар зүйлийн 10.19-т “Үндэсний их баяр наадмаар жороо морины уралдааныг зохион байгуулж болно.” гэж заасан.

Дээрх хуулийн заалттай холбогдуулан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, жороо морины уралдааны эрх зүйн зохицуулалтыг хуульд нэмж тусгах шаардлагатай болсон.

1996 оноос эхлэн жил бүрийн баяр наадмын сүүлийн өдөр буюу 7 дугаар сарын 13-ны өдөр Уяачдын наадмаар жороо морины уралдааныг зохион байгуулсаар ирсэн бөгөөд жороо морины уралдааныг зохион байгуулах, уяачид цол, чимэг олгох зохицуулалт нь тодорхойгүй байсан.

Үндэсний их баяр наадмаар зохион байгуулах жороо морины уралдааны уяачид улс, аймаг, сумын цол, чимгийг олгох нь эрт үеэс уламжлагдан ирсэн жороо морины уралдааныг дэлгэрүүлэн хөгжүүлэх, наадамчин олны жороо морио дээдлэн хүндлэх, хайрлах, хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэх, уяачдын хөдөлмөрийг үнэлэхэд чухал ач холбогдолтой гэж үзлээ.

4.1. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

4.1.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө: Түүх, соёлын үнэт зүйлийн талаарх мэдлэг, хосгүй үнэт зүйлийн үнэ цэнийг бодитоор үнэлэх, ирээдүй хойч үед өвлөн залгамжлуулах эрх орчин бүрдэнэ.

4.1.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө: Эдийн засагт үзүүлэх нөлөө байхгүй болно.

4.1.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө: Эрт үеэс уламжлагдан ирсэн жороо морины өв соёлыг ирээдүй хойч үедээ түгээн дэлгэрүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ. Мөн жороо морины уралдааныг хөгжүүлэх эрх зүйн үндэс бүрдэж, уяачдын идэвх, санаачилга, эрх зүйн байдал дээшилж, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах эрх зүйн орчин боловсронгуй болно. Үүний зэрэгцээ Үндэсний их баяр наадмаар Жороо морины уяачийн эрх, үүрэг тодорхой болж Жороо морины уяачийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж, жороо морины уралдааныг зохион байгуулах эрх зүйн нөхцөл бүрдэнэ.

4.1.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө: Хууль батлагдсанаар байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжтой нийцсэн байна

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар	
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх		Үгүй	Ийм төрлийн зохицуулалт биш.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		Үгүй	Ийм төрлийн зохицуулалт биш.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх		Үгүй	Ийм төрлийн зохицуулалт биш.
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм		Олон нийтэд тэгш эрхтэй төрийн үйл ажиллагааг түгээж байгаа.
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм		Бүлгүүдийг тусгайлан тодорхойлж, тэдэнд үзүүлэх үр нөлөөг тооцсон.
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм		Ийм төрлийн зохицуулалт биш.

	1.3.2. Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм		Ийм төрлийн зохицуулалт биш..
	1.3.3. Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх		Үгүй	Ийм төрлийн зохицуулалт биш.
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх		Үгүй	Хязгаарлалт байхгүй.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх		Үгүй	Хязгаарлалт байхгүй.
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм		Ийм төрлийн зохицуулалт биш.
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх		Үгүй	Хамааралгүй.
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх		Үгүй	Хамааралгүй.
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/		Үгүй	Хамааралгүй.

Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм		Хүн, Хуулийн этгээд
4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх		Үгүй	Хамааралгүй.
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм		Жендэрээр ялгасан зохицуулалт байхгүй.

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Тийм зохицуулалт байхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)		Үгүй	Тийм зохицуулалт байхгүй.
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх		Үгүй	Тийм зохицуулалт байхгүй.
2. Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй	Тийм зохицуулалт байхгүй.
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх		Үгүй	Хязгаарлагдмал өрсөлдөөн үүсгэхгүй.
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3. Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4. Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5. Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

6. Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх		Үгүй	Тийм зохицуулалт байхгүй.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх		Үгүй	Тийм зохицуулалт байхгүй.
7. Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8. Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
9. Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт		Үгүй	Тийм зохицуулалт байхгүй.

	хийх шаардлага тавигдах эсэх			
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх		Үгүй	Тийм зохицуулалт байхгүй.
10. Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.3.Инфляц нэмэгдэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11. Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4. Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

5. Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6. Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	нөхцөл байдалд нөлөөлөх эсэх			
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8. Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2. Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

3. Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сэргээр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сэргээр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сэргээр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4. Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сэргээр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5. Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6. Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7. Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

